



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 04 өдөр

Дугаар A/511

Мөрөн сум

Гэрээ байгуулах эрх олгож, захиалагчийн
төлөөлөгч томилж, ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 45 дугаар зүйлийн 45.3, 46 дугаар зүйлийн 46.1.3, 46.1.6, 46.3, Засгийн газрын 2021 оны “Журам батлах тухай” 160 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2022 оны A/95 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сан дахь зураг төслийн сангийн хөрөнгөөр санхүүжихээр батлагдсан Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн биеийн тамирын гадна талбайн тохижилтын ажлын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох ХӨАНӨГ/2023 дугаартай тендерт 6,000,000 (Зургаан сая) төгрөгийн үнийн санал ирүүлсэн “Нануто” ХХК-ийн тендерийг зөвшөөрч, тус компанид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсүгэй.

2. “Нануто” ХХК-ийн гэрээтэй холбоотой асуудлаар захиалагчийг төлөөлж харилцах, холбогдох шийдвэрийг гаргах, зөвлөх үйлчилгээний гэрээний нөхцөлүүдийн хэрэгжилтэд хяналт тавих зөвлөх үйлчилгээг хүлээн авах, гэрээ дүгнэх чиг үүрэг бүхий “Захиалагчийн төлөөлөгч”-өөр аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-г томилж, зөвлөх үйлчилгээ хүлээн авах, нийлүүлэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Захиалагчийн төлөөлөгч: Б.Оюунтуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Ажлын хэсгийн гишүүд: Б.Баасанжав (Аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын Барилгын материалын үйлдвэрлэл, лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга: Б.Минжүүржаргал (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах албаны мэргэжилтэн)

3. Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн биеийн тамирын гадна талбайн тохижилтын ажлын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээнд заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх, гэрээний хэрэгжилтийг хангах, зөвлөх үйлчилгээг хүлээн авах, гэрээг дүгнэх, санхүүжилтийн гүйцэтгэл баталгаажуулах, гэрээ болон гэрээний хэрэгжилтийн мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэх цогц системд тус тус нийтлэх, захиалагчийн төлөөлөгчийн чиг үүрэг хэрэгжүүлсэн тухай ажлын үр дүнг тайлагнах, тайланг хавтаст хэрэг болгон архивд шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулахыг захиалагчийн төлөөлөгч (Б.Оюунтуяа)-д, захиалагч, тендерт оролцогч (тухайн тендерт оролцсон нийт оролцогч)-ийн тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг зохион байгуулсан баримт бичиг, гэрээ дүгнэсэн акт, зөвлөх үйлчилгээ хүлээн авсан шийдвэр, санхүүжилтийн гүйцэтгэл зэрэг баримт бичгийг цахим болон бичгийн хэлбэрээр хавтаст хэрэг болгон

архивд шилжүүлэхийг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Б.Минжүүржаргал)-д тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Должинсорогдог)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ